

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ БАЙГУУЛЛАГЫН  
УДИРДЛАГАТАЙ БАЙГУУЛСАН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

2023 оны 06 дугаар сарын 15

Улаанбаатар хот

Д/а	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6
1	<p>Арга хэмжээ №1 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилтын хэрэгжилтийг өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилтын хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнана.</p>	<p>Хүргүүлэх тайлан, тоо</p>	2	<p>- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан "Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат, дээвэр, фасад, инженерийн шугам сүлжээг өргөтгөн шинэчилж иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ" гэсэн манай байгууллагын чиг үүрэгт хамаарах арга хэмжээний хэрэгжилт 80 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд хэрэгжилтийг хангаж, улирал бүр хугацаанд нь тайлагнаж байна.</p> <p>1.Нийслэл, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 он дамжин хэрэгжиж буй нийтийн зориулалттай орон сууцны барилгын 20 цахилгаан шатны ажил хийгдэж байна. Тус 20 цахилгаан шат шинэчлэлийн ажлаас 19 цахилгаан шатны ажил 100 хувь бүрэн хэрэгжиж улсын комисст хүлээлгэн өгсөн бөгөөд 1 цахилгаан шатны угсралтын ажил 60 хувьтай хэрэгжиж байна.</p> <p>- Нийтийн зориулалттай орон сууцны барилгын ашиглалтын шаардлага хангахгүй 20 цахилгаан шатны шинэчлэлийн ажлын гүйцэтгэгч байгууллага шалгарсан бөгөөд "Фүшили элеватор" ХХК 4 цахилгаан шат, "Төвхөн трейд" ХХК 6 цахилгаан шат, "Оакс экспресс монголиа" ХХК 10 цахилгаан шатны шинэчлэлийн ажил гүйцэтгэх гэрээг тус тус байгуулсан. Үүнээс 19 цахилгаан шатыг улсын комисст хүлээлгэн өгсөн байна.</p> <p>Үүнд:</p>	80%

- "Фүшили элеватор" ХХК-ийн гүйцэтгэж буй 2 цахилгаан шат угсралтын ажил дуусаж, улсын комисст 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр хүлээлгэн өгч байнгын ашиглалтад оруулсан. Мөн БГД-ын Голден парк хотхоны 2 лифт 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр ажлын талбай дээр бууж, угсралтын ажил бүрэн хийгдэж 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Хотын стандарт, хяналтын газраар бүрэн магадлал, туршилтыг хийлгэж, цахилгаан шатыг хүлээн авах комисс 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр ажилласан.

- "Төвхөн трейд" ХХК 6 лифтийн угсралтын ажил гүйцэтгэхээс 5 цахилгаан шат ажлын талбай дээр бууж, угсралтын ажил хийгдэж дууссан бөгөөд 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр ХСХГ-аар бүрэн магадлал хийлгэхээр ажиллаж байна. 2023 оны 02 дугаар сарын 27, 03 дугаар сарын 13, 27 болон 04 дүгээр сарын 07, 18-ны өдрүүдэд ажлын үе шат бүрд захиалагчийн хяналтыг тавьж ажилласан. Захиалагчийн хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр гүйцэтгэгч байгууллагад заавар зөвлөгөөг өгч арилгуулан ажилласан. Дээрх 5 лифтэнд 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр бүрэн магадлалыг хийлгэж, цахилгаан шатыг хүлээн авах комисс 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр ажилласан байна. Тус компанийн гүйцэтгэж буй 1 цахилгаан шат нь ажлын талбай дээр бууж, угсралтын ажил хийгдэж эхэлсэн бөгөөд 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр захиалагчийн хяналтыг тавьж ажилласан.

"Оакс экспресс монголиа" ХХК-ийн гүйцэтгэх 10 цахилгаан шатны тээвэрлэлт хийгдэн, 2023 оны 03 дугаар сарын 26-ны өдөр ажлын талбай дээр бууж, угсралтын ажил бүрэн хийгдэж дууссан. Тус 10 цахилгаан шатуудад бүрэн магадлалыг 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр хийлгэн, улсын комисст хүлээлгэн өгөх албан хүсэлтийг 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Хотын стандарт, хяналтын газарт хүргүүлсэн. Цахилган шатуудыг хүлээн авах улсын комисс 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр ажилласан болно.

- "Төвхөн трейд" ХХК-ийн гүйцэтгэж буй 1 цахилгаан шатын угсралтын ажил хийгдэж хийгдэж байна.

2. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжих нийтийн зориулалттай орон сууцны барилгын 4 цахилгаан

				шатны шинэчлэлийн ажлыг "Оакс экспресс Монголиа" ХХК гүйцэтгэхээр шалгарч, 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр гэрээ байгуулсан бөгөөд гэрээний дагуу захиалга хийгдэж байна.			
2	Арга хэмжээ №2 Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл тусламжаар хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний явц, хэрэгжилт, үр дүнгийн талаар Хотын Ерөнхий менежерт мэдээлэл өгч ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Тайлант хугацаанд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр байхгүй болно.	-		
3	Арга хэмжээ №3 Дараа онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, төсөл арга хэмжээнүүдийн төсвийн төсөл, урсгал зардлын төсөв, төсвийн төсөөлөлд Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн саналыг авч ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	2023 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, төсөл арга хэмжээнүүдийн төсвийн төсөл, урсгал зардлын төсөв, төсвийн төсөөлөлд Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн саналыг авч ажилласан.	100%		
4	Арга хэмжээ №4 Төрийн дээд шатны болон орон нутгийн удирдах байгууллага, албан тушаалтанд өргөн барих, бодлого, зохицуулалтын шийдвэрийн төсөлд Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн саналыг авч ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Дээд шатны болон орон нутгийн удирдах байгууллага, албан тушаалтанд өргөн барих, бодлого, зохицуулалтын шийдвэрийн төсөлд Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн саналыг тухай бүр авч ажилласан.	100%		
5	Арга хэмжээ №5 Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, алба хаагчдыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд мерит тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн батлуулж, гэрээний заалт, холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмыг мөрдөн зөрчил гаргалгүй ажиллуулж байна. Албан хаагчид хийж хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа сар, улирал, жилийн хугацаатайгаар төлөвлөдөг ба гүйцэтгэл, үр дүнг ажилчдын шуурхай зөвлөгөөнөөр хэлэлцэн, дүгнэж ажилласан. Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын байрны тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээтэй уялдуулан дүгнэсэн.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, алба хаагчдыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд мерит тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн батлуулж, гэрээний заалт, холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмыг мөрдөн зөрчил гаргалгүй ажиллуулж байна. Албан хаагчид хийж хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа сар, улирал, жилийн хугацаатайгаар төлөвлөдөг ба гүйцэтгэл, үр дүнг ажилчдын шуурхай зөвлөгөөнөөр хэлэлцэн, дүгнэж ажилласан. Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын байрны тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээтэй уялдуулан дүгнэсэн.	100%		

				<p>Ажилчдыг ажлын байранд тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шагнал, урамшуулал, тэтгэмж олгох;</li> <li>- Ажлын үр дүнг, гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын байрны тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээтэй уялдуулан үнэн бодитой үнэлж, дүгнэх;</li> <li>- Ажлын ачааллыг оновчтой хуваарилах;</li> <li>- Ажиллах таатай орчныг бий болгох;</li> <li>- Шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, үр чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах;</li> <li>-Хамт олны дунд найрсаг уур амьсгалыг бүрдүүлэх;</li> </ul>				100%
6	<p>Арга хэмжээ №6 Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлнэ.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	100		Иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлж зөрчил дутагдал гаргалгүй ажиллаж байна.		100%	
7	<p>Арга хэмжээ №7 Албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлнэ.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	100		<p>Байгууллагын стратеги төлөвлөгөөнд үндэслэн “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр 2021-2023 он”, “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөр”-ийг боловсруулж Даргын 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/12 дугаар тушаалаар баталсан. Энэхүү хөтөлбөрийг ажилчдын шуурхай зөвлөгөөн дээр танилцуулж мэдээллийн самбарт байршуулсан. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах 2023 оны төлөвлөгөөг Газрын даргаар батлуулан биелэлтийг ханган 97 хувийн биелэлттэй ажиллаж байна.</p> <p>2023 оны хагас, бүтэн жилийн биелэлтийг хугацаанд нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.</p>		97%	
8	<p>Арга хэмжээ №8 Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгч, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гаргах арга хэмжээг авна.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	100		<p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн систем egr.uiaapbaatar.mn нэгдсэн сайтаар 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 9 өргөдөл гомдол, хүсэлт ирсэн бөгөөд тухай бүр шуурхай шийдвэрлэн ажилласан байна. Иргэд аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулж</p>		100%	

				хуулийн хугацаанд нийслэлээс дэвшүүлсэн зорилтот түвшинд шийдвэрлэсэн.	
9	Арга хэмжээ №9 Нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүргийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Нийслэлийн засаг даргын захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерээс өгсөн үүрэг чиглэл, бодлого шийдвэр, тушаал, Нийслэлийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөр нийт 65 үүрэг даалгавар тус бүрийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж, биелэлтийг тухай бүр тайлагнасан. Дундаж хэрэгжилт 100 хувьтай байна. Улаанбаатар хотын Ерөнхий менежерээс өгсөн үүрэг чиглэл, бодлого шийдвэр, тушаалын хэрэгжилтийг тухай бүр хангаж ажилласан.	100%
10	Арга хэмжээ №10 Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд инженер, дэд бүтцийн чиглэлээр хэрэгжүүлэх онцлог ажлаа тусгайлан зааж, тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр ханган, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 2 зорилт, 18 арга хэмжээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрээр хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа ба хэрэгжилт 97 хувийн гүйцэтгэлтэй байна. Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлэх онцлог ажлаа тусгайлан зааж, тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр ханган биелэлтийг улирал бүр удирдах дээд байгууллагад тайлагнан ажилласан.	100%
11	Арга хэмжээ №11 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасны дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, олон нийтийг танилцах боломжоор хангана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Түүнчлэн Нийслэлийн эрх зүйн нэгдсэн сан болох UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудсанд байгууллагаас гаргасан 2023 оны захирамжлалын баримт бичгийг тухай бүр байршуулан цахим санг эрхэлж хөтлөх тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
12	Арга хэмжээ №12 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах	Сар бүр мэдээллийг хуулийн дагуу ил тод мэдээлсэн байдал, тоо	12	Төсвийн хөрөнгийн зарцуулалтын дүн мэдээг сар бүрийн 06-ны дотор 70 удаа шилэн дансны <a href="http://www.shilendans.ub.gov.mn/home">http://www.shilendans.ub.gov.mn/home</a> цахим хуудсанд бүртгэж үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль болон Шилэн дансны тухай хуулийг мөрдөн хэрэгжүүлж ажилласан.	100%

	мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллана.			
НИЙТ ДУНДАЖ ХУВЬ:				97%

**Төсвийн Ерөнхийлөн захирагч**

Тайланг хянасан:  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН

ЗАХИРАГЧ ..... /Д.СУМЪЯАБААЗАР/

.....  
(огноо)

**Тайланг хянасан:**

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА ..... М.БАЯРАА

.....  
(огноо)

Тайлагнасан: **Төсвийн Шууд захирагч**  
"УЛААНБААТАР ЛИФТ" ОНӨТҮГ-ЫН  
ДАРГА



.....  
(огноо)

/Д.ГАН-ЭРДЭНЭ/